



ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ ХК

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 27 өдөр

Дугаар: 22

Улаанбаатар хот

Компанийн жилийн санхүүгийн тайланг дүгнэх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, 80 дугаар зүйлийн 80.2, 96 дугаар зүйлийн 96.5, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, 24 дүгээр зүйлийн 24.3, “Нексия глобал монголиа аудит” ХХК-ийн 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хараат бус аудиторын дүгнэлт, Сангийн сайдын 2017 оны 01 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 3.3.18-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Нексия глобал монголиа аудит” ХХК-ийн хараат бус аудиторын тайлан, дүгнэлтийг үндэслэн “Үндэсний давхар даатгал” ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна гэж дүгнэсүгэй.

2. Компанийн санхүү, үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлант)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Ч.Тавинжил)-д даалгасугай.

4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо (Ц.Дашдондог)-нд үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ТАВИНЖИЛ